

Шаравын Чоймаа
“Монголын нууц товчоон”, Лувсанданзаны “Алтан товч”
эхийн харьцуулсан судалгаа”
хэмээх бүтээлийн тухай

Д.Цэрэнсодном (ШУА)

Үе үеийн эрдэмтдийн уйгагүй хичээл зүтгэлийн ачаар “Монголын нууц товчоо”-г хятад галигаас сэргээн сийрүүлэх, тал бүрээс нь тайлбарлах ажил хийгдсээр ирлээ.

Одоо “Монголын нууц товчоо” судлалыг цааш гүнзгийрүүлэхэд монголын түүхийн бусад сурвалж бичгүүдтэй эх бичиг судлалын аргаар харьцуулан судлах нь уг дурсгал бичгийн зарим нэгэн эргэлзээтэй буюу зөрчилтэй, дутуу доргон мэдээ баримтыг тодруулахад онцгой чухал ач холбогдолтой болохыг Ш.Чоймаа багш соргогоор олж харж, эл бүтээлээ туурвижээ. Бидэнд энэ хэр мэдэгдэж буй монголын түүхийн хожуу үеийн сурвалж бичгүүдээс “Нууц товчоон”-ы үндсэн үйл явдал өгүүлэмжийг бараг бүрнээр багтаасан зохиол бол Лувсанданзаны “Алтан товч” мөн болно. Ийм учраас “Монголын нууц товчоо”-г судлагчдаас академич С.А.Козин, Ц.Дамдинсүрэн нарын эрдэмтэд энэ хоёр дурсгал бичгийг харьцуулж, ялангуяа утгазүйн хувьд нэгийг нь нөгөөгөөр нөхөн сэргээх журмаар ашиглаж байлаа.

Ш.Чоймаа эл бүтээлдээ, “Монголын нууц товчоон”-ы 282 зүйлээс “Алтан товч”-той адилтган жиших бололцоо бүхий 268 зүйлийн үг өгүүлбэр бүхнийг мөр мөрөөр жишин сийрүүлж, үсэг зурлага, үг ухагдахуун бүрийг нягтлан, ямар нэгэн мадаг сэжигтэй буюу зөрөөтэй зүйлд тайлбар судалгаа хийсэн нь монголын түүхийн энэ хоёр гол дурсгал бичгийн аль алины судалгаанд ахиц гаргасан шинэ сонин ажил болсныг олзуурхан тэмдэглэж байна.

Тухайлбал, сударч Лувсанданзан түүхэн явдлыг “Нууц товчоон”-оос сийрүүлэн авахдаа эндүү ташаа ухаарсан буюу хуулбарлагч бичээчдийн ч мадаг сэжиг байж болох илэрхий эндэгдэл гэмээр олон үг

хэллэгийг үсэг зурлага, авиа зүй, үгзүйн олон талаас нь нягтлан тайлбарласан жишээ цөөнгүй байгаагаас дурдвал¹:

"Монголын нууц товчоон"-ы 124дүгээр зүйлийн "**nembe'e isgei**" гэснийг "*nemüry-e šejegei* (шаазгай)"² гэж, мөн 134дүгээр зүйлийн "**ja'ut-quri**" гэдгийг "*цаг-un törü*"³, 140дүгээр зүйлийн орчин цагийн монгол хэлний "зах (дээлийн)" гэдэг үгийн олон тооны хэлбэрт буй "**jaqas**" гэдгийг "*aq-a*"⁴ хэмээн буулгасан зэргийг хэлж болно.

Үүнээс гадна Мин улсын эхэн үеэр хятад үсгээр галигласан "Нууц товчоон"-ы эхэд гээгдсэн буюу уул эхэд байгаагүй зарим нэгэн үг хэллэгийг Лувсанданзаны ашигласан эхээр нөхөн сэргээж болох бололцоо буйг Ш.Чоймаа хэд хэдэн газар тэмдэглэсэн нь анхаарал татах зүйлийн нэг юм. Жишээ нь: "Нууц товчоон"-ы 30дугаар зүйлд Буху Хатаги

¹ Дурдсан үг хэллэгийн талаар зохиогчийн хийсэн тайлбарыг уг бүтээлээс нь шууд эшлэн, зүүлтээр оруулав.

² Орчин цагийн монгол хэлний "эсгий" гэдэг үгийг эртний монгол хэлэнд "sisegei ~ sisigei" гэж хэлдэг байжээ. Дунд үеийн монгол хэлэнд уг үгийн эхний "s" суларч эхэлсэн боловч хэвээр байжээ. Тухайлбал, "МНТ"-ны уйгуржин монгол эхэд "sisegei" гэж бичсэнийг "МНТ"-г хятадаар галигч бээр төвөггүй ухаж, зөв орчуулжээ. Гэхдээ XIV зууны эцэс гэхэд, уг үгийн эхний "s" гийгүүлэгч сулран сугарч эхэлснийг "МНТ"-ны хятад галигч эх тодорхой харуулж байна. Үүнийг, "МНТ"-ны 202 дугаар зүйлд "sisgei to'urqatu" (эсгий туургат) гэж галигласан атлаа дараах 203 дугаар зүйлд "isgei tu'urqatan" (эсгий туургатан) гэж галигласнаас үзэж болно. Өнөөгийн "эсгий" гэдэг үг дунд үеийн монгол хэлэнд "sisegei" гэсэн хэлбэр, дуудлагатай байсныг "Мукаддимат-Ал-Адаб" толь (sisegei), "Монгол хуа-й-юй" толь (sisige) болон монгол хэлний эртний хэв байдлыг хадгалсан Могол, Дагуур зэрэг хэл аялгууны баримтууд баттай гэрчилж байна. Харин XVII зууны үеийн Лувсанданзан болон түүний бичээч нарт "sisegei" гэсэн бичлэгтэй үг огт ухагдсангүй тул эх судрын дагуу "šejegei" гэж хуулан бичээд, "шаазгай" гэсэн тайлбар хажууд нь хаджээ. Энэ үгийн өмнөх "нөмрөг" (nemürge) гэдэг үгийг ч судрын байдлаар нь хуулсан тул "nemürge" гэж уншихад төвөгтэй болжээ. Зөвхөн энд өгүүлснийг хураангуйлан хэлбэл, XVII зууны түүхч Лувсанданзанд ч, XIV зуунд хятадаар галиглагч бичгийн хүнд ч ялгалгүй, "МНТ"-ны уйгуржин монгол бичгээр бичсэн "өвгөн" судар байжээ.

³ "МНТ"-ийн хятад галигч эхэд "ja'ut-quri" хэмээн галиглаад, ноёны хэргэм гэсэн хятад орчуулга хадсан үгийн гарлыг судлаачид янз янзаар мөшгин тайлбарладаг. XVII зууны түүхч Лувсанданзан энэ үгийг сайн ойлгоогүй, түүний дээр эх судрын бичлэг нь бүдэг балархай байсан бололтой. Лувсанданзан бээр Чингис хаанд их л хүндэтгэлтэй цол өгсөн биз гэж бодоод "цаг-un törü" гэж уншжээ. Гэхдээ судрын бичлэг нь ойр байсан байх ёстой. "МНТ"-ны судлах нөр их ажилд 3 боть бүтээлээрээ алдартай Баяр гуай "ja'ud quri" гэдэг үгийн тухай тун саяхан илтгэл тавьсан бөгөөд "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл"-ийн хятад эх, "Алтан улсын түүх" зэргээс магадлан үзэж, "quri" бус "quru" байх ёстой гэж үзсэн нь их л сонин байна. Учир нь Лувсанданзанд байсан "МНТ"-ны эхэд лав "quru" гэж бичсэн тул "törü" гэж төсөөлөн уншсан байх ёстой. Үгийн эхний "j" үсгийг, үгийн дунд тохиолдох "j" буюу "s" диг бичдэг зуршил элбэг байсан тул " " гэж бичсэнийг "цаг-un" гэж Лувсанданзан уншсан бололтой.

⁴ Уг эх сударт " " гэж бичсэний эхний титэмийн шүд нь ялимгүй богино байсан тул "aq-a" гэж уншжээ. Ашигласан сударт нь "jaqa" гэсэн хэлбэртэй байсан аж.

дүү Бодончарын араас нэхэн одох цагт "esen-ü ükübeü kemel"⁵ (амьд уу үхсэн үү хэмээн) гэж хэлсэн үг хийгээд 82дугаар зүйлд Тэмүжин тайчуудын гараас мултарч шөнө Онон голын харгианд нуугдан хэвтэж байхад нь Сорхон шар тааралдаад "usun-a älmei ügei : oᠣᠳᠠᠭᠢᠭᠤᠨᠠ ᠮᠣᠷ ᠤᠭᠡᠢ"⁶ хэмээн хэлсэн зүйр үгийг Ш.Чоймаа "Нууц товчоон"-ы эхэд байсан болов уу гэж үзжээ.

Бас "Нууц товчоон"-ы 86дугаар зүйлд "tergen-tür iseri-yin döro" гэснийг "Лу. Алтан товч"-д "tergen iseri-yin alam-tur"⁷ гэсний "алам" буюу "хөндий, завсар, зай" гэсэн утгатай энэ үг угтаа "Монголын нууц товчоон"-ы эхэд байсан байж болох юм гэдэгтэй би санал нэгдэж байна.

Бидний төлөөлөл болгон авч дурдсан энэ хэдэн баримтаас үзэхэд "Монголын нууц товчоо", Лувсанданзаны "Алтан товч" эхийн харьцуулсан судалгаа" (Улаанбаатар, 2002) хэмээх эл бүтээл нь монголын түүхийн гол хоёр сурвалж бичгийн аль алины нь судалгааг урагш ахиулахад хувь нэмрээ хүртээсэн өвөрмөц сонин, шинэлэг ажил болжээ.

Энэхүү шинэ сонин ажлыг улам нягт нямбай, өө сэвгүй болгохсон гэх сэтгэлийн үүднээс миний нүдэнд торсон нэгэн зүйл бөгөөс "Монголын нууц товчоо"-г нангиад үсгээр галиглагч их эрдэмтэн Хуа, Йэйгэ нар хийгээд сударч Лувсанданзан нарын монгол хэлний мэдлэг боловсролын цар хэмжээг арай чамласан буюу дутуу үнэлсэн юм уу гэлтэй санаа зохиолын 4дүгээр талын 9дүгээр тайлбар⁸, 20дугаар хуудасны 7дугаар тайлбар⁹, 43дугаар хуудасны 121дүгээр тайлбар¹⁰, 59дүгээр хуудасны 153дугаар тайлбараас цухалзаж байх мэт санагдана.

⁵ Лу. "Алтан товч"-ийн "esen-ü ükübeü kemel" гэсэн хэсэг үг "МНТ"-д үгүй. Харин "Хураангуй алтан товч"-д "ükübeü abuu [aba uu] gejü erin irebe" гэж буй. "МНТ"-нд байх ёстой мэт.

⁶ Энэ хэсэг "МНТ"-ны эхэд байсан болов уу гэж үзээд, галиглан тавив.

⁷ "МНТ"-ны хятад галиг эхэд "döro" (доор) гэж байх үгтэй байр тохиролцох Лу. "Алтан товч"-ийн үг нь "alam-tur" болно. Энэ нь магадгүй хоёр монгол эхийн зөрөө ч байж болно. "alm-a" (алам) гэдэг нь газрын том нүхийг нэрлэхээс гадна тэргэний хоёр хоёр хүрдний хоорондох зайг бас хэлдэг ажээ. "iseri" (исэр) гэж одоо түшлэггүй сандлыг хэлдэг боловч дундад үеийн монгол хэлэнд ор гэсэн утгатай байсан нь "Хуа-й-й-юй" толиос мэдэгдэж буй. Тийн үзвэл, "iseri-yin alam-tur kürtele" гэх нь ор дэрний зай завсарт хүртэл гэсэн утгатай болно.

⁸ МНТ-ны эх сударт " " гэж бичсэнийг Лувсанданзан "gögügelen" гэж ташаа уншжээ. Өөрөөр хэлбэл уг үгийн төгсгөлийг " " (-lere) гэж бичсэнийг " " (-len) гэж гаргажээ. Ер нь энэ үеийн монгол бичгийн дурсгалд үгийн дунд орсон "г" үсэг тун жижиг, гаргац муутай, заримдаа 2 ацаг мэт бичсэн байдаг юм.

⁹ "МНТ"-нд "naruyitcu" гэж хятадаар галигласан энэ үгийг судлаачид "налах, хазайх" гэсэн утгатай хэмээн тайлбарладаг. Лу. "Алтан товч"-ийн тус үгийг Л.Лигети "naruyitcu" гэж "МНТ"-ны хятад галигийг баримтлан галигласан бол С.А.Козин "naruyiju"(?) гэж галиглаад, эргэлзсэн тэмдэг тавьжээ. Уг үгийн эхний титэм, шүдийг "na" буюу "a" хоёрын аль нэгээр унших ёстой. Зүтгэн сарвайх байдал заасан "арайж" (aruyiju) гэсэн үг байж магадгүй гэж үзэв.

¹⁰ "МНТ"-ны эх сударт "sirya ayta-tan naiman morid" гэж бичсэнийг Лувсанданзан бээр гүйцэд ухаж чадсангүй. Ялангуяа "ayta-tan" гэдгийн "tan" дагавар түүнд ойлгомжгүй байсан тул орхижээ. "МНТ"-ны энэхүү холбоо үгийг хожмын түүхчид ташаа ойлгож, "Чингисийн найман шарга агт (морь)" гэсэн буруу

Өмнөх мэргэдийн бүтээлийг өнөө цагийн эрдэмтэд мухар сохроор даган бишрэлгүй, судлан шинжлэгч хүний хурц оюунаар шүүн тунгааж, авах гээхийн ухаанаар хандах нь зүйн хэрэг ч тэдний эндүү мэдгийг орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтын өнгөнөөс зэмлэн буруутгахдаа тухайн цаг үетэй нь холбож, эерүүлэн бичвээс зохистой болов уу хэмээн бодсоны үүднээс үүнийг дурдав.

Эрдэм номын мөр ээдрээгүй цагаан байх болтугай.

Академич Д.Цэрэнсодном

2003.02.10

хэллэг буй болжээ. Сурвалж бичгүүдийн баримтыг харгуулан нягталбал, Тэмүжиний "шарга агттан найман морьд"-ыг дээрэмчин авч одсон хэрэг 1178 оны шар нохой жилийн зун Сэнгүр горхины Хар Зүрхэний Хөх нуурт нутаглаж байх үест болжээ. Тэмүжиний бага насанд учирсан энэхүү үнэн түүхт үйл хэргийг бараг бүх л сурвалж бичигт дурдан тэмдэглэсэн байх ажээ. Гэхдээ зарим сурвалж, Рашид-ад-дины "Судрын чуулган"-д "Чингис хаан бага залуу байхад нь түүний бараа бологчид, цэргүүд нь түүнээс зайлж одсон тул түүнд туслах хүнгүй болжээ. Гэтэл нэг өдөр монгол аймгуудаас дээрэмчид ирж, түүний морьдыг нь хөөгөөд явчихжээ..." гэж тэмдэглэсэн шиг ямар зүсмийн хэдэн морь дээрэмдсэнийг тодорхой дурдаагүй байна. Тухайн үйл хэргийг бус зөвхөн "шарга агттан найман морьд" гэснийг хэрхэн тэмдэглэснээр хөөн дурдвал, "Хураангуй алтан товч"-д "найман шарга", Саган сэцэний "Эрдэнийн товч"-д "найман шарга агтас", Жамбын "Асрагч нэртийн түүх"-д "найман шарга морь", Мэргэн гэгээний "Алтан товч" болон Жамбадоржийн "Болор толь"-д "найман шарга адуун", Инжаннашийн "Хөх судар"-т "эзний эмээлийн найман шар агт эрдэнийн морь" гэх мэтээр ташаа бичиж иржээ. Энэ нь "шарга агт бүхий найман морь" гэсэн үг билээ. Өдгөө, хөдөөгийн адуугаа эрсэн эрлийн хүн "шарга азаргатай хэдэн адуу үзэв үү" гэж асуудагтай адилтгаж болох юм. "МНТ"-ны "sirqa aqta-tan" хэмээх үг хийгээд дундад үеийн монгол хэлний "-tan" дагаврын судалгаа (Ш.Чоймаа) өгүүлэлд тодорхой бичсэн буй.